

БАТЛАВ.НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ХОРОО

ДАРГА:...../Ж.ГАНБОЛД/



БАТЛАВ."ВАНХҮҮ"ХХК-ИЙН

ЗАХИРАЛ:...../Б.БОРОЛЗОЙХҮҮ/



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ _____

Улаанбаатар хот
(аймаг, сум, дүүрэг)

2017 оны 02 сарын 15 -ны өдөр

Нэг талаас *Нийслэлийн нийтийн биеийн тамир спортын хороо* (цаашид “Захиалагч гэх”) түүнийг төлөөлж.....

Нөгөө талаас “Ванхүү” ХХК (цаашид “Ажил гүйцэтгэгч гэх”) түүнийг төлөөлөн Захирал Б.Боролзойхүү нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь гэрээг харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу **400 ширхэг медалийг** хугацаанд нь гүйцэтгэж захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлнэ.

1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

2. Гэрээний хугацаа

2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.

2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа _____

2.3. Ажил эхлэх хугацаа: 2017 он 2 сарын 15 өдөр

2.4. Ажил дуусах хугацаа 2017 он 5 сарын 20 өдөр

3. Ажлын хөлс

3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс **₮6000000 (зургаан сая)** төгрөг байна.

3.2. Ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг хүлээлгэн өгөх үед хөлсийг төлнө. (Хэрэв ажлыг тодорхой хэсгээр, үе шаттай гүйцэтгэхээр тохиролцсон бол тухайн хэсгийн ажлын үр дүнгээр хөлсийг хэсэгчлэн төлөхөөр тохиролцож болно.)

4. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.

4.2. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

4.3. _____

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.

5.2. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.

5.3. Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.

5.4. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

5.5. _____

6. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд _____ хувийн алданги төлнө.

6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

6.3. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

7. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

7.2. Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

8. Бусад заалт

8.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)

8.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний Арбитрын Хэрэг Шийдвэрлэх Дүрмийн дагуу Монгол Улсад Эцэслэн шийдвэрлүүлнэ.

9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

9.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

10. Нэмэлт нөхцөл

11. Талуудын хаяг

Захиалагч:

Гүйцэтгэгч:

Хаяг: Шийсэлтэй
Шийсэлтэй бизнесийн танхим
Сүхбаатар хороо
Утас: Уулжингийн
М. Мандалбаяр 99020610
Гарын үсэг: [Харын үсэг]

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 14-р хороо, Хайлаастын 1-1 тоот
Утас:357102
Нэгтгэл Бодлогч: Ч. Мандалбаяр
Гарын үсэг: Ч. Мандалбаяр

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)